



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 33

Мөрөн

Орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилж,
ажиллах, журам эрх үүргийг батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “н”, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 4, Компанийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. “Могойн гол” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд таслах эрхтэй оролцох орон нутгийн өмчийн төлөөлөгчөөр аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн (Ц.Бэхбаяр)-ийг томилж, түүний хэрэгжүүлэх эрх хэмжээ, ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэлийг ханган зохион байгуулахыг компанийн ТУЗ-ийн дарга (Б.Базардамбуу), гүйцэтгэх захирал (Б.Хашбат) нарт, өмчийн төлөөлөгчийн эрх хэмжээ, ажиллах журмыг хэрэгжүүлж, тайлагнахыг орон нутгийн өмчийн төлөөлөгч (Ц.Бэхбаяр)-д тус тус даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

ТОГТООЛЫН ТӨСӨЛ

119160065

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2020 оны 4 дүгээр сарын 13-ны
өдрийн 33 дугаар тогтоолын хавсралт

“Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд
орон нутгийн өмчийн төлөөлөгч Ц.Бэхбаярын ажиллах журам,
хэрэгжүүлэх эрх үүрэг

Могойн гол ХК-ийн 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг төлөөлөх орон нутгийн өмчийн төлөөлөгч Ц.Бэхбаяр нь дараах журам эрх үүргийг хэрэгжүүлнэ.

1. Компанийн нийт хувьцааны орон нутгийн өмчид ногдох хувийг дангаараа төлөөлж, хувьцаа эзэмшигчдийн хуралд таслах эрхтэй оролцоно.
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг дэмжиж санал өгөх
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг батлах санал өгөх
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг төлөвлөсөн хэмжээгээр батлах санал өгөх
5. Компанийн ногдол ашиг хуваарилахгүй байх Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг дэмжиж санал өгөх
6. Эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс гаргасан “Компанийг өөрчлөн байгуулах тухай” төслийг хэлэлцүүлж татгалзсан санал өгөх
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох санал хураалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 367 дугаар тогтоолоор баталсан “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-ыг баримтлан зохион байгуулна.
8. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд аймгийн орон нутгийн өмчийн төлөөлөлөөр ажиллах гишүүдэд дараах этгээдийг нэр дэвшүүлж дэмжиж санал өгнө. Үүнд:
 - а. Ц.Ганзориг Боловсрол соёл урлагийн газрын дарга- Төрийг төлөөлөх
 - б. Э.Аззаяа- аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга- Төрийг төлөөлөх
 - с. Ц.Бэхбаяр- аймгийн ОНӨГ-ын мэргэжилтэн- Төрийг төлөөлөх
9. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хараат бус гишүүнд дараах этгээдүүдийг нэр дэвшүүлж дэмжих. Үүнд:
 - а. Ч.Уртнасан.- Хараат бус гишүүн
 - б. Ц.Мөнгөншагай- Хараат бус гишүүн